



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/12

Булган сум

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2023 оны 09 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн дотуур байрны халаалт, цэвэр усны гадна талын 3 хос шугам солих засварын ажлын гүйцэтгэгчээр “Булган мээж” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн захирал (Э.Түвшинмөнх)-д олгосугай.

2.Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Булган мээж” ХХК-ийн захирал (Г.Ганбаатар)-д даалгасугай.

4.Ажил гүйцэтгэхэд шаардлагатай 78,000,000 (далан найман сая) төгрөгийг Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010014